

ТҮЙН ГОЛ ФОРМААЦЫН ШИНЭ ОЛДВОРЫН ТУХАЙ

Б. ЭНХБАЯР

Геологийн Судалгааны Төв

Баянхонгорын Жинст Өлзийт сумын хил залгаа нутаг Түйн ба Бүрдийн голуудын сав газар голдуу тектоник блок илэрч, Дундговийн сери, доод пермийн боржинг үл нийцлэгээр хучиж залуу хурдсаар хучигддаг 2070 м зузаан *Cordaites ex gr. Singularis (Neub) S.Meyen*, *Rhynchopora zoljaensis Tolm.*, *Terrakea aff. зэрэг* мөр хөлтөн, хөвд биетний үлдэгдэл агуулсан полимикт, аркоз элсэн чулуу, туф-элсэн чулуу, конгломерат, суурилаг, дундлаг, хүчиллэг вулканит тэдгээрийн туф зэргээс тогтсон зузаалгийн 1963 онд А.А.Храпов нар Түйн гол свит (формаац) болгон ялгасан байна.

Үүнтэй төстэй хурдас Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутаг Баруун уул гэдэг уулын өвөр хэсэг Их давааны өвөрт 1.2x2.5 км² талбайд, мөн энэ давааны өврийн сархиагархаг хажуу хэсэгт нэлээд сайн илэрч үүсгэсэн байх бөгөөд агаарын гэрэл зураг дээр энэ формаац нь уллаж байгаа дунд пермийн холимог вулканитийн формаацаасаа арай цайвар дэвсгэртэй ба үүн дээр тунамал зузаалгийн үелэл нь тод ялгарсан зурваслаг байдлаар харагддаг онцлогтой.

Их давааны орчимд илрэх энэ формаац нь зүүн ургаш уналтай моноклираль атираа үүсэх ба зүүн талаасаа Шар- ус голын боржингоор зүсэгддэг бөгөөд хойт ба баруун хэсгээрээ дунд пермийн холимог вулканоген формаац дээр угаагдлын гадаргуугаар хиллэнэ. Атирааны харагдах жигүүр нь 70° орчим өнцгийн уналтай болно. Түйн гол формаац нь элсжин, зануужин, төрөр бүрийн вулканоген чулуулгийн туф, андезит, туф конгломерат зэргээс тогтоно. Энэ орчимд хийсэн зүсэлтийг үзүүлэв (Дороос дээш).

Зузаан, м

| | |
|---|----|
| 1. Хар-саарал өнгийн дацит | 20 |
| 2. Том, дунд хайргатай, хар-саарал өнгийн конгломерат..... | 38 |
| 3. Хар-саарал өнгийн алевролит (амьтны үлдэгдэлтэй)..... | 50 |
| 4. Хар-саарал цахиурлаг алевролит | 22 |
| 5. Конгломерат, алевролитийн нарийн үетэй ногоовтор-саарал туфэлсжин..... | 72 |
| 6. Хар-ногоон өнгийн дотороо цахиурлаг алевролитийн үетэй андезит-порфир..... | 40 |

| | |
|---|----|
| 7. Пиритийн шигтээтэй цахиурлаг чулуулаг | 9 |
| 8. Хар-саарал алевролит | 32 |
| 9. Хар саарал өнгийн туффит | 57 |
| 10. Эвэржсэн хар-саарал өнгийн алевролит..... | 60 |
| 11. Ногоовтор-саарал хувирсан андезит порфир..... | 27 |
| 12. Хар-бараан өнгийн алевролит | 12 |
| 13. Хар-саарал туфэлсжин..... | 20 |
| 14. Хар-саарал цахиурлаг алевроэлсжин | 28 |
| 15. Саарал өнгийн аркоз элсжин | 11 |
| 16. Хар-саарал өнгийн эвэржисэн алевролит | 80 |
| 17. Хөхөвтөр саарал өнгийн андезит..... | 3 |
| 18. Хар-саарал өнгийн аркоз элсжин | 60 |

Нийт зузаан.....641

Түйн голын формацын зузаан нь 2070 м боловч манай талбайд энэ хурдасны багаахан хэсэг нь үлдсэн байх тул 640 м-ээс хэтрэхгүй зузаантай болох нь харагддаг.

Энэ формацын чулуулаг нь уллаж байгаа дунд пермийн Хүрээмарал формацын дацит дээр 40 м орчим зузаантай конгломератаар угаагдлын гадаргуу үүсгэн байрладаг бол өмнө хэсгээрээ дээд дөрөвдөгч - орчин үеийн делюви – пролфвийн сэвсгэр хурдсаар хучигдсан байна.

Энэ давхрагадасын вулканомикт элсжин болон алевролитын үеүүд дотроос гэлбэг олддог амьтны үлдэгдэлийг палеонтологич Л.Нямсүрэн судлаад дараах төрөл зүйлийг тогтоосон:

Spiriferella saranae (Vern), Neospirifer cf nitiensis Dien, Pseudosyrinx sp, Pseudosyrinx kolymaensis Tolm, Canerinelloides obrutschewi lich, Canerinelloides janischewskiana (Step), Cancrinelloides ogsuerensis (Zav), Canerinelloides munumus Gan, Terrakea borealis Gan, Terrakea belkhhini gan, Linoproductus limatus Zav.

Эдгээр амьтны үлдэгдэл нь дээд лермийн Уфимын ярусын төвшинг заадаг бөгөд Төв Монголын пермийн хурдсанд олддог тэнгисийн амьтны үлдэгдэл *Terrakea borealis Gan, Terrakea belkhhini Gan* нь Баянхонгорын бүсийн Түйн голын орчимд олдож дээрх тэнгисийн зах хязгаарыг тогтоож байсан бол түүнээс баруун тийш Бууцагааны мультын хойт хэсэгт шинээр олдож байгаа нь эрдэмтэн Д.Оролмаагийн үзэж байгаагаар уг зах хязгаарыг баруун тийш нь татах боломжтой болгож байна.